



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/621

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдсэн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд 5, 6, 7, 8 дугаар сард зарцуулах зардалд зориулан 19 980 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 19 980 000 төгрөг /арван есөн сая есөн зуун наян мянга/-ийг аймгийн Байгаль хамгаалах сангийн 1.1-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ийн хүрээнд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 28-ны өдрийн
А/621 дүгээр захирамжийн хавсралт



**“ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГТ ХОГ ОТВОЛДОЖ ДАРЖ ЗАМ ГАРГАХ
АЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДАЛ**

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /120 хоног/	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1.	Хогийн цэгт ажиллах шатахууны зардал	л	4800	2400	11 520 000
2.	Тос, масло	багц	3	610 000	1 830 000
3.	Сэлбэг, хэрэгсэл	багц	3	2 000 000	6 000 000
4.	Хөдөлмөр хамгааллын зардал	Хүн/өдөр	120	4000	480 000
5.	Жолоочид урамшуулал, хоолны зардал	Хүн/өдөр	100	1500	150 000
Нийт					19 980 000

-oOo-